



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Замын-Үүд сумын Засаг дарга 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДГА-2019/3/СТА-ТТЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

(Хотын нэр оруулах)

2019 он

Тэргүүлэх аудитор: .....Ч.Ариунаа

Утас: ..... Цахим хаяг: .....

Аудитын менежер: .....

Утас: ..... Цахим хаяг: .....

Аудитор: .....Ц.Лүндэгмаа

Утас: ..... Цахим хаяг: .....

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

---

1	Аудитын гэрчилгээ .....	3
2	Аудитын тайлан .....	6
2.1.	Оршил.....	6
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	6
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	7
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	7
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	8
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	9
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	9
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	9
2.8.1	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар .....	10
2.8.2	Төсвийн төвлөрүүлэн захирагчын шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар.....	14
2.8.2.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал .....	16
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	16
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	16
2.11.	Шилэн дансны мэдээлэл .....	18
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	18
2.13.	Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл: .....	19
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	20
3	Менежментийн захидал .....	21
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	24

---

## 1 Аудитын гэрчилгээ



### ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,  
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,  
Утас: (705) 2-27-34

2019. 03. 28 № 1-6/381

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ЗАМЫН-ҮҮД СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Н.АЛДАРБАЯР ТАНАА

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Замын-Үүд сумын Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

#### Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Замын-Үүд сумын Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

#### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Замын-Үүд сумын Засаг даргын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Аудитын гол асуудал

1. Төсвийн шууд захирагчийн 3 санхүүгийн тайланд хязгаарлалттай дүгнэлт өгсөн.
2. Төвлөрүүлэн захирагчийн өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлээгүй. Үүнд:
  - Төсвийн тухай хуулийн 4.1.24-т заасныг зөрчихгүй байх, орон нутгийн төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн хөрөнгийг улсын төсвийн байгууллагын өмчлөлд аймаг, сумын ИТХ, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын зөвшөөрлийн дагуу шилжүүлэх, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан журмын 6.1 дэх заалт "... хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажил нь төрийн эсхүл орон нутгийн өмчид заавал бүртгэгдэх бөгөөд барилга байгууламжийг барьж дуусах хүртэл, худалдан авсан тоног төхөөрөмжийг ашиглалтад хүлээн авсан эцсийн гүйцэтгэлийн дүнгээр захиалагч байгууллага эргэлтийн бус хөрөнгөөр бүртгэн санхүүгийн тайландаа тусгана" гэсэн заалт
  - Сум хөгжүүлэх сангийн журмыг мөрдөж ажиллах, сангаас олгосон зээлийн авлагыг 2011 оноос хойш хөөн авлагын үлдэгдлийг үнэн зөвөөр гаргаж тогтоох, санхүүгийн тайланг үнэн зөв болгож тайлагнах зөвлөмж
  - Сангийн сайдын 2016 оны 345 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, тайлагнал, хяналт тавих журам"-ын 4.21-д заасан Барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмжийн зардлыг хооронд нь шилжүүлэх, батлагдсан нэр, байршлыг солих, хүчин чадлыг өөрчлөхийг ... хориглоно гэсэн заалтыг мөрдөж ажиллах зөвлөмж
3. Сумын төсвийн нийт орлогыг 6,218.0 сая төгрөгөөр төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 6,187.1 сая төгрөг орж 30.9 сая төгрөгөөр төлөвлөгөө тасарсан байна. Мөн аймагт төвлөрүүлэх орлогыг 28.9 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна.
4. Сумын төсвийн хөрөнгө оруулалтаар анх 12 ТАХ-нд 327.5 сая төгрөг баталсан ба 2018 оны 12 сард тодотгол хийж нийт 51 ТАХ-нд 1165.8 сая төгрөгийн төсөв баталсан байна. Орон нутгийн төсвийн төсөл боловсруулахдаа Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан аргачлалыг баримтлаагүй байна. Хөрөнгийн зардлыг нэр төрлөөр ангилж үзэхэд орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой 295.0 сая төгрөгийн зардал байгаа бөгөөд бусад 864.2 сая төгрөгийн зардал нь хамаарахгүй зардал байна.

Эдгээр нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, эрх ба үүрэг, хэмжилт гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### Үүрэг, хариуцлага

Замын-Үүд сумын Засаг дарга Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

## 2 Аудитын тайлан

### 2.1. Оршил

Замын-Үүд сумын Засаг дарга 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Сумын Засаг дарга Алдарбаяр-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2,3-д заасны дагуу Замын-Үүд сумын Засаг дарга 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Замын-Үүд сумын Засаг дарга 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.03.21-нээс 2019.03.28-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.03.28-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, газрын ахлах аудитор Ц.Лүндэгмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Замын-Үүд сумын Засаг дарга 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-т 2019.03.01-ны өдрийн 1/208 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Замын-Үүд сумын Засаг дарга талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Замын-Үүд сумын Засаг дарга “Хүн ам ая тухтай орчин нөхцөл бүрдсэн нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, олон улсын төсөл, хөтөлбөр, төсөв, санхүүгийн зөв бодлогоор хангаж, байгальд ээлтэй дэвшилтэт технологи бүхий аж үйлдвэр, жижиг дунд үйлдвэрийг байгуулах, мэдлэгт суурилсан эдийн засгийг тэнцвэртэй хөгжүүлэх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

- Эдийн засгийн салбаруудыг тэнцвэртэй хөгжүүлж, тогтвортой өсөлтийг хангах замаар үр ашгийг дээшлүүлэх
- Сумын нийгэм, эдийн засгийн хөгжилд тохиромжтой дэд бүтцийг бүрдүүлж, амьдрал, бизнесийн таатай орчныг сайжруулах
- Нийгмийн үйлчилгээг иргэдийн хэрэгцээнд нийцүүлэн төгөлдөржүүлж, чанар, хүртээмжийг сайжруулан хүний хөгжлийг хангах
- Байгаль орчныг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах, нөхөн сэргээх замаар “Ногоон хөгжил”-ийн бодлогыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх
- Иргэдийн оролцоог хангасан тогтвортой, хариуцлагатай бүтэц, тогтолцоог бүрдүүлэн “Сайн засаглал”-ыг төлөвшүүлэх
-

Замын-Үүд сумын Засаг дарга удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 12 байгууллага, нэгж 2018 оны санхүүгийн тайландаа аудит хийж баталгаажуулахаас 12 байгууллага аудитад хамрагдсан байна.

Төрийн аудитын байгууллагаас Замын-Үүд сумын Засаг дарга эрх асуудлын хүрээний байгууллагад санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

#### Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлт гаргасан	Түүвэрлэсэн	Итгэл үзүүлсэн	Гэрээгээр хийлгэсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	3	1	0	8	0
2	ТБӨӨААН	0	0	0	0	0
	Дүн	3	1	0	8	0

#### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Замын-Үүд сумын Засаг дарга мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Замын-Үүд сумын Засаг дарга санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Замын-Үүд сумын Засаг дарга санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн програм хангамж ашиглаагүй байна.

Замын-Үүд сумын Засаг дарга дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөгүй гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Замын-Үүд сумын Засаг дарга бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 10 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 1 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлын 2 хувиар сонгов.

Хөрөнгийн дүн их тул материаллаг байдлын суурь өндөр тооцогдох тул зардлын үзүүлэлтээр сонголоо.

Замын-Үүд сумын Засаг дарга 2018 оны нийт зардлын дүн 17,271,326.8 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 345,426.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн материаллаг биш боловч цаашид санхүүгийн тайлан, тодруулгад материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй зарим асуудлыг толилуулж байна.

Замын-Үүд сумын Засаг дарга болон төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагчийн хэмжээнд 483.5 сая төгрөгийн, төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэмжээнд 1419.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 564.9 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулав.

Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудлыг хэрхэн ангилж, шийдвэрлэсэн байдлыг энэ тайлангийн 2.13-т нэгтгэсэн байдлаар үзүүлэв.

Асуудлыг өмнөх түвшинд хийсэн аудитын явцад гарсан асуудал, төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад түүвэрт хамрагдсан асуудлаас илэрсэн асуудал гэсэн ангиллаар үзүүлэв.Үүнд:

2.8.1 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар

### **Асуудал 1: Төсвийн төлөвлөлт**

#### **Засаг даргын тамгын газар:**

1.Засаг даргын нөөц хөрөнгийн зардлын төсөв 60.9 сая төгрөгөөр батлагдаж гүйцэтгэлээр 59.9 сая төгрөгийн зардал гарсан байна. Нөөц хөрөнгөөс байгууллагуудад хөрөнгийн дэмжлэг, шагнал урамшууллыг хавтгайруулан олгосон, сургалтын болон хүлээн авалт, харшийн шинэ жилийн үйл ажиллагааны зардал, тамирчдын замын зардал, хувцасны үнэ, дуу бичлэг, гэх мэт зардал гаргаж төсвийг үрэлгэн зарцуулсан байна.

2.Сумын ИТХ-аас 2018.12.07 -ны өдрийн №10/03 тоот тогтоолоор тус байгууллагын урсгал зардлын төсвийг 11.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж төсөвт өөрчлөлт оруулан баталсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 34.2-т заасан “Засаг дарга дараах тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголыг боловсруулж тухайн шатны ИТХ-д өргөн мэдүүлнэ, 34.2.1.Дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон, 34.2.2. Урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, орон нутгийн төсөв алдагдалтай болох нөхцөл байдал бий болсон, 34.2.3. хөтөлбөр төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт өөрчлөлт оруулах” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

#### **Шийдэл:**

1. Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх заалтыг хэрэгжүүлж төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах зөвлөмж өгөв.

2. Сангийн сайдын тушаалаар баталсан “ЗД-ын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 5.1-д заасан “Засаг даргын нөөц хөрөнгөөс хөрөнгө оруулалтын зардал гаргах, олгосон хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахыг хориглоно” заалтыг мөрдөж ажиллах зөвлөмж өгөв.

## **Асуудал 2: Орлого**

### **Засаг даргын тамгын газар:**

Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг 2.0 сая төгрөгөөр төлөвлөж баталсан бөгөөд гүйцэтгэлээр орлого тайлагнагдаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйл 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

**Шийдэл:** Төсвийн тухай хуулийн 41.2.1-д заасны дагуу орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллах зөвлөмж өгөв.

### **Асуудал 2: Худалдан авалт, гэрээний биелэлт, хэрэгжилт**

#### **Иргэдийн Төлөөлөгчдийн хурал:**

1. 3-р цэцэрлэгийн төв хаалганд үүдний таамбар хийхэд зарцуулагдах төсөв хөрөнгө шийдвэрлэх гэрээний 1.2 дахь заалтад “3.0 сая төгрөгийн санхүүжилтэд багтаан хийх” гэж тусгасан байна. Гэтэл ИТХ-ын төлөөлөгчдийн 2-р тойрогт ажиллах зардлын төсвөөс 3751.0 мянган төгрөг шилжүүлсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг зөрчсөн байна.

**Шийдэл:**Замын-Үүд сумын 2-р цэцэрлэгээр 751.0 мянган төгрөгийг төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. ИТХ-ын төлөөлөгчдийн 1-р тойрогт ажиллах зардлаас иргэн Ц.Долгортой тоглоомын талбайд 4.7 сая төгрөгөөр хүүхдийн тоглоом, сүүдрэвч барих гэрээ байгуулсан ба тоглоомын талбайг хүлээн авсан акт байхгүй байна.

ИТХ-ын төлөөлөгчдийн 2-р тойрогт ажиллах зардлаас иргэн Г.Баттөрөөс 520.0 мянган төгрөгөөр сагсан бөмбөгийн шит авсан гэх боловч суурилуулсныг нотлох баримтгүй, хүлээн авсан акт байхгүй байна.

ИТХ-ын төлөөлөгчийн 4-р тойрогт ажиллах зардлаас Чандмань бадрал ХХК-аар Сүлд багийн 11-р хэсгийн гадна шугам сүлжээний 6.7 сая төгрөгийн ажил гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан. Гэрээнд ажил дуусах хугацаа тодорхойгүй, тус ажлыг хүлээн авсан акт байхгүй байна.

**Шийдэл:** Иргэн Ц.Долгор, иргэн Г.Баттөр болон Чандмань бадрал ХХК-ны гэрээний дагуу гүйцэтгэх ажлуудыг бүрэн дуусгуулж 11920.0 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн авч, холбогдох газруудын данс бүртгэлд тусгуулах албан шаардлага өгөв.

### **Замын-Үүд сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль:**

Хоол, урсгал зардал, хичээл үйлдвэрлэлийн зардал гэсэн 3 төрлийн зардлаас зарцуулалт хийхдээ нийт 85,745,4 1 мянган төгрөгийн худалдан авалтыг шууд хийсэн байна.

**Шийдэл:**Албан шаардлага өгөв.

## **Замын-Үүд сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургууль:**

2018 онд тус сургуулийн хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх /210902/ гэсэн эдийн засгийн ангилалаар 22820,9 мянган төгрөгийн төсөв батлагдан 100 хувийн гүйцэтгэлтэйгээр зарцуулагдсан байна. Уг ангилалын хүрээнд төсвийн шууд захирагч МУЗГ-ын 129 тоот тогтоолын шалгуур болгон ТБОНӨХБАҮХАТХ-ын 8,1 болон 8,4 заалтыг үндэслэл болгон худалдан авах ажиллагааг удирдан зохион байгуулж ажиллаагүй байна.

**Шийдэл:**Зөрчил арилгах албан шаардлага өгөв.

## **Асуудал 3: Зардлын данстай холбоотой асуудал**

### **Иргэдийн Төлөөлөгчдийн хурал:**

Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан “Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал”-д байхгүй нэр төрөл болох Хурлын даргын нөөц хөрөнгийн зардал гэж 60959.7 мянган төгрөгийн төсөв баталсан. Хурлын даргын нөөц хөрөнгөөс ИТХ-ын төлөөлөгчдийн тойрогт ажиллах зардал, оюутан сурагчдын сургалтын төлбөр болон биеийн тамирын уралдаан тэмцээнд оролцогчдод дэмжлэг, зочид төлөөлөгчдийг хүлээн авах зардал, байгууллагуудад хөрөнгийн дэмжлэг, шагнал урамшуулал, шинэ жилийн баяр зэрэгт нийт 59951.7 мянган төгрөгийн зардал гаргаж төсвийг үрэлгэн зарцуулсан.

**Шийдэл:** Сумын ИТХ-ын даргын нөөц хөрөнгийн зардлын төсөв батлахгүй байх, сумын ИТХ-аас баталсан ИТХ-ын даргын нөөц хөрөнгийн зардлын 2019 оны /30.0 сая төгрөгийн/ төсвөөс зарлагын гүйлгээ гаргахгүй байх гэсэн албан шаардлага өгөв.

## **Асуудал 4: Өмнөх аудит болон зөвлөмжийн биелэлт, үр дүн**

### **Иргэдийн Төлөөлөгчдийн хурал:**

Өмнөх онд аудитаар 18400.0 мянган төгрөгийн зөрчилд өгсөн “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, эдийн засгийн ангилал тус бүрээр ажил гүйлгээг бүртгэж байх, оюутны тэтгэлэгт хөтөлбөрийн сонгон шалгаруулалтыг баримтжуулж гэрээний биелэлтэд хяналт тавих, бараа материалыг тайлант хугацаанд үнэн зөв тайлагнах” зөвлөмжүүдийг хэрэгжүүлээгүй,

Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан “Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал”-д байхгүй нэр төрөл болох Хурлын даргын нөөц хөрөнгийн зардал гэж 60.9 сая төгрөгийн төсөв баталсан. Хурлын даргын нөөц хөрөнгөөс ИТХ-ын төлөөлөгчдийн тойрогт ажиллах зардал, оюутан сурагчдын сургалтын төлбөр болон биеийн тамирын уралдаан тэмцээнд оролцогчдод дэмжлэг, зочид төлөөлөгчдийг хүлээн авах зардал, байгууллагуудад хөрөнгийн дэмжлэг, шагнал урамшуулал, шинэ жилийн баяр зэрэгт нийт 59.9 сая төгрөгийн зардал гаргаж төсвийг үрэлгэн зарцуулсан гэсэн үндэслэлээр тус байгууллагын 2018 оны санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

**Шийдэл:** Замын-Үүд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны дарга А.Анхтуяад сахилгын шийтгэл оногдуулах албан шаардлага хүргүүллээ.

## **Асуудал 4: Балансын данстай холбоотой асуудал**

### **Иргэдийн Төлөөлөгчдийн хурал:**

Тус байгууллага жилийн эцсийн дүнгээр 4700.0 мянган төгрөгийн үнэ бүхий бараа материалын үлдэгдэлд хийсэн тооллогыг хуулийн хүрээнд зохион байгуулаагүй, ЗДТГ,ЗАА,ИТХ-ын хөрөнгийг нийлүүлж тоолсон зөрчил илэрлээ.

**Шийдэл:** Байгууллагын үндсэн хөрөнгө болон эргэлтийн хөрөнгийг хуулийн хүрээнд зохион байгуулах албан шаардлага өгөв.

Тайлант жилийн эцэст Чандмань бадрал ХХК-ийн нягтлан бодогчтой 11-р хэсгийн гадна шугам сүлжээний ажлын төлбөрийн тооцоо нийлж ИТХ 6700.0 мянган төгрөгийн илүү төлөлттэй гэсэн тооцоо нийлсэн акт үйлдсэн боловч санхүүгийн тайланд авлага үүсгэн бүртгээгүй байна. Мөн иргэн Ц.Долгорт 4700.0 мянган төгрөг шилжүүлээд ажил хүлээж аваагүй байхад санхүүгийн тайланд авлагаар бүртгээгүй байна.

**Шийдэл:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1 дэх заалтыг хэрэгжүүлж нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар бүртгэж тайлагнах зөвлөмж өгөв.

### **Замын-Үүд сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль:**

Тус сургууль 6267.2 мянган төгрөгийн төсвийн хэмнэлтийг нотлох баримтгүйгээр Төсвийн байгууллага болон хувийн байгууллагад шилжүүлэн авлага үүсгэсэн байна. 2017 онд үүссэн 10577.1 мянган төгрөгийн авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

**Шийдэл:** Төсвийн байгууллага болон хувийн байгууллагад шилжүүлэн авлага үүсгэсэн 6267.2 мянган төгрөгт төлбөрийн акт тогтоов.

2017 онд үүссэн 10577.1 мянган төгрөгийн авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авах талаар албан шаардлага өгөв.

### **Замын-Үүд сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургууль:**

2018 оны үйл ажиллагааны үр дүнд бий болсон төсвийн хэмнэлтийг төвлөрүүлэлгүйгээр Үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэгч "Идэр өлзий дархан уул" ХХК-д 3249,2 мянган төгрөгийг төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал зардлаас, НДХ-д 3555,3 мянган төгрөгийг ажил олгогчоос төлөх нийгмийн даатгал болон цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардлаас, "Чандмань бадрал" ХХК-д түлш халаалтын зардлаас 4998,5 мянган төгрөгийг тус тус илүү шилжүүлэн нийт 11802,9 мянган төгрөгийн авлага үүсгэсэн.

**Шийдэл:** Авлага үүсгэсэн 11802.9 мянган төгрөгт төлбөрийн акт тогтоов.

### **Замын-Үүд сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургууль:**

Тайлант хугацааны эцэст батлагдсан төсвөөс гарсан хэмнэлтээр авлага үүсгэж, холбогдох зардлыг бууруулан бүртгэсэн байна. Үүнд: Чандмань бадрал ХХК-д ирэх жилийн цэвэр бохир усны зардлын санхүүжилтэд 315,290 төгрөг, үдийн цайны санхүүжилтэнд Даян сайн сайхан ХХК-д 2,195,600 төгрөгийг шилжүүлсэн байна.

**Шийдэл:** Авлага үүсгэсэн 2510.9 мянган төгрөгт төлбөрийн акт тогтоов.

### Замын-Үүд сумын 4 дүгээр цэцэрлэг:

Ажлаа хүлээлгэн өгсөн нярвын бараа материалын тайлангийн үлдэгдэл санхүүгийн тайлангийн үлдэгдлээс 664311 төгрөгөөр дутуу байна

Дэвжих мөнхийн од ХХК-д 970600 төгрөг, иргэн Ариунболорт 1145740 төгрөгийг 2018 оны 5-р сарын тооцооны үлдэгдэл гэж тус тус төлсөн боловч 2018 оны хагас жилийн тайланд өглөгөөр бүртгэгдээгүй, ямар материал хэн хүлээн авч юунд зарцуулсан, хэн хариуцах нь тодорхойгүй байна

**Шийдэл:** Дээрх зөрчлүүдэд 2780.6 мянган төгрөгийн нэг төлбөрийн акт тогтоов.

### Замын-Үүд сумын 5 дугаар цэцэрлэг:

2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт 6951.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй бөгөөд үүнээс НДШ-ийн илүү төлсөн авлага 3236.0 мянган төгрөг байна.

**Шийдэл:** Авлага үүсгэсэн 6951.0 мянган төгрөгт төлбөрийн акт тогтоов.

2.8.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 10 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 7 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 1 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэнээс гадна 3 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Сум хөгжүүлэх сангийн тайланд 3 чиглэлээр аудитын 4 горим сорил гүйцэтгэж үнэлэхэд 3 асуудлыг алдаа зөрчилтэйд тооцож шийдвэрлэсэнээс 2 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

#### Үүнээс: Залруулгын ангилал

№	Залруулгын товч утга	Мөнгөн дүн (мянган төгрөгө өр)	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлттэй холбоотой	Тайлант хугацаанд гарсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллын алдаа	Өмнөх тайлант хугацаанд гарсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллын алдаа	Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлттэй холбоотой
1.	Төсвийн шууд захирагчдын тайланд залруулсан	90492.0		90492.0		

Замын-Үүд сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

алдааг нэгтгэл тайланд тусгаж тайлагнаагүй			
2.	СХС-аас зээл авсан иргэдийн зээлийн хүү, хугацаандаа төлөөгүй зээлд алданги тооцуулж авлагын дүнг нэмэгдүүлэв.	21764.2	21764.2
3.	СХС-ийн мөнгөн гүйлгээний тайланд зээлийн эргэн төлөлтийг тайлагнаагүй, үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгийг орлогоор бүртгэсэн байв.	169906.3	169906.3
4.	Мөнгөн хөрөнгө авлагын журнал хөтлөөгүй, СХС-ийн мөнгөн хөрөнгийн тайланд зээлийн эргэн төлөлт, хүүгийн орлогыг тайлагнаагүй байв.	148142.1	148142.1
5.	Сум хөгжүүлэх сангийн журмын дагуу зээлийн хүү, алдангийг тооцоогүй байна.	21764.2	21764.2
Дүн		452068.8	452068.8

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	4	967457.1	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	1	967457.1	

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд орууллаа.

**2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдсэн Соёл спортын ордны гадна цахилгааны ажилд 35.1 сая төгрөг, гадна цэвэр, бохир ус, дулаан хангамжийн ажилд 49.8 сая төгрөг, гадна зам талбайн ажилд 80.0 сая төгрөгийн нийт 164.9 сая төгрөгийн төсөв батлагдсан байна. Эдгээр ажлын гүйцэтгэгч Уртын-Уул ХХК-д 34.0 сая төгрөг, Чандмань бадрал ХХК-д 48.8 сая төгрөг, Гантулгатрейд ХХК-д 78.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Эдгээр ажлын санхүүжилтийг 2019 онд улсын төсвөөс шийдвэрлэгдсэн эсэх, хөрөнгийг данс бүртгэлд тусгасан эсэхийг нягтлах нь зүйтэй.

**2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Замын-Үүд сумын Засаг дарга чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд 16 хөтөлбөр, 87 арга хэмжээнд зориулан 13010.8 сая төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Замын-Үүд сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төсвийн орлогын нийт гүйцэтгэл 13005.6 сая төгрөг буюу 99.9 хувь, зардлын нийт гүйцэтгэл 12975.8 сая төгрөг буюу 99.7 хувьтай байгаа нь татварын бус орлого 61.9 сая төгрөгөөр тасарсан, аймагт төвлөрүүлэх орлогыг 28.9 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн, байгууллагуудын төсвийн хэмнэлтээс шалтгаалжээ.

Төсвийн орлого, зардлын төлөвлөгөөний биелэлтийг харьяа байгууллагаар нь авч үзвэл:

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
<b>1</b>	<b>ОРЛОГО</b>	<b>13,010,833.20</b>	<b>13,005,623.38</b>	<b>(5,209.82)</b>
2	Татварын орлого	4,347,275.40	4,378,355.78	31,080.38
3	Татварын бус орлого	1,870,724.10	1,808,787.80	(61,936.30)
4	Орон нутгийн хөгжлийн сан	270,256.20	270,210.20	(46.00)
5	Тусгай зориулалтын шилжүүлэг	6,400,127.50	6,400,127.50	-
6	Сум хөгжүүлэх сан	121,000.00	148,142.10	27,142.10
7	Нөхөн сэргээлтийн сан	1,450.00		(1,450.00)
<b>8</b>	<b>ЗАРЛАГА</b>	<b>13,010,833.20</b>	<b>12,975,826.00</b>	<b>(35,007.20)</b>
1	ИТХ	151,157.30	146,969.60	(4,187.70)
2	ЗДТГ	752,479.10	714,700.30	(37,778.80)
3	ЗАА	48,868.70	46,294.10	(2,574.60)
4	Тохижилт	541,164.60	541,064.50	(100.10)
5	Сумын хөрөнгө оруулалт	1,165,762.00	1,154,110.60	(11,651.40)
6	Сум хөгжүүлэх сан	121,000.00	116,000.00	(5,000.00)
7	Нөхөн сэргээлтийн сан	1,450.00	-	(1,450.00)
8	Орон нутгийн хөгжлийн сан	270,256.20	270,210.20	(46.00)
9	Сургууль1	1,563,107.00	1,557,042.30	(6,064.70)
10	Сургууль2	1,191,613.80	1,190,583.70	(1,030.10)
11	Сургууль3	1,234,991.00	1,234,987.80	(3.20)
12	Цэцэрлэг1	391,776.80	391,760.40	(16.40)
13	Цэцэрлэг2	341,422.80	328,576.40	(12,846.40)

**Замын-Үүд сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

14	Цэцэрлэг3	350,303.30	344,951.90	(5,351.40)
15	Цэцэрлэг4	384,304.10	382,564.40	(1,739.70)
16	Цэцэрлэг5	200,935.40	186,278.90	(14,656.50)
17	Цэцэрлэг6	60,460.30	59,900.30	(560.00)
18	Хувийн цэцэрлэг	316,608.20	316,608.20	-
19	Хувийн сургууль	119,411.30	119,411.30	-
20	БНӨЭМТ	245,193.50	245,193.50	-
21	Татаас /аймагт төвлөрүүлэх/	3,558,567.80	3,529,691.90	(28,875.90)
22	Төвлөрүүлэг		98,925.70	
	<b>Зөрүү</b>	<b>-</b>	<b>29,797.38</b>	<b>29,797.38</b>

### **2.11. Шилэн дансны мэдээлэл**

Замын-Үүд сумын Засаг дарга Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

### **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар хангалтгүй байна.

1. Төсвийн тухай хуулийн 4.1.24-т заасныг зөрчихгүй байх, орон нутгийн төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн хөрөнгийг улсын төсвийн байгууллагын өмчлөлд аймаг, сумын ИТХ, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын зөвшөөрлийн дагуу шилжүүлэх, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан журмын 6.1 дэх заалт "... хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажил нь төрийн эсхүл орон нутгийн өмчид заавал бүртгэгдэх бөгөөд барилга байгууламжийг барьж дуусах хүртэл, худалдан авсан тоног төхөөрөмжийг ашиглалтад хүлээн авсан эцсийн гүйцэтгэлийн дүнгээр захиалагч байгууллага эргэлтийн бус хөрөнгөөр бүртгэн санхүүгийн тайландаа тусгана" гэсэн заалтыг хэрэгжүүлэх зөвлөмж:

*2018 онд улсын төсвийн байгууллагын өмчлөлд шилжүүлсэн 864.2 сая төгрөгийн хөрөнгө байгаа бөгөөд эдгээрээс Гадаадын иргэн харьяатын Дорноговь дахь газарт хөрөнгө оруулалтаар худалдан авсан ТАХ-г тухайн байгууллагын данс бүртгэлд бүртгэхийг холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлэхийг аймгийн Засаг даргад хүссэн байна.*

2. Сум хөгжүүлэх сангийн журмыг мөрдөж ажиллах, сангаас олгосон зээлийн авлагыг 2011 оноос хойш хөөн авлагын үлдэгдлийг үнэн зөвөөр гаргаж тогтоох, санхүүгийн тайланг үнэн зөв болгож тайлагнах зөвлөмж:

*Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн тооцоог үнэн зөв хийгээгүй байсанд аудитын явцад зээлийн хүүгийн авлага, алданги тооцууллаа.*

3. Сангийн сайдын 2016 оны 345 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, тайлагнал, хяналт тавих журам”-ын 4.21-д заасан Барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмжийн зардлыг хооронд нь шилжүүлэх, батлагдсан нэр, байршлыг солих, хүчин чадлыг өөрчлөхийг ... хориглоно гэсэн заалтыг мөрдөж ажиллах зөвлөмж:

*Сумын ИТХ-ын 2018 оны 3 сарын 19-ний өдрийн 08/01 тогтоолоор өөрчлөлт оруулж анх батлагдсан ТАХ-ээс 100.0 сая төгрөгийн 3 ТАХ-г хасаж оронд нь Гадаадын иргэн харьяатын Дорноговь аймаг дахь газарт суудлын авто машин нийлүүлсэн байна.*

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд аудитын явцад дахин нягталсан болно.

### 2.13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Замын-Үүд сумын Засаг дарга 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт илэрсэн алдаа, зөрчлийн 29.7 хувь буюу 564.9 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 2.2 хувь буюу 42.0 сая төгрөгийн зөрчилд хохирлыг барагдуулах төлбөрийн акт тогтоож, 11.3 хувь буюу 214.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 56.8 хувь буюу 1081.5 сая төгрөгийн зөрчлийг засах, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлээ.

Төрийн аудитын байгууллагаас аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил түүний шийдвэрлэлийн байдлыг дор нэгтгэн үзүүлэв. Үүнд:

(сая төгрөг)

№	Байгууллагын ангилал	Илрүүлэлт						Залруулга	
		Зөрчил		Алдаа		Бүгд дүн		Тоо	Дүн
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	ТТЗ	5	967,5	5	452,1	10	1419,6	5	452,1
2	ТШЗ	36	368,6	1	112,8	42	481,4	1	112,8
3	ТБӨААН								
	Дүн	41	1336,1	6	564,9	52	1901,0	6	564,9

### Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт

(сая төгрөг)

Үүнээс: Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт

№	Байгууллагын ангилал	Залруулаагүй алдаа, зөрчил	Хариуцлага тооцуулах санал				
			Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	

**Замын-Үүд сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
<b>1</b>	ТТЗ	5	967,5	0	0	0	0	5	967,5	0	0	0	0
<b>2</b>	ТШЗ	36	368,6	9	39,9	7	196,3	19	114,0	1	18,4	0	0
<b>3</b>	<b>ТБӨААН</b>												
	Дүн	41	1336,1	9	39,9	7	196,3	24	1081,5	1	18,4	0	0

## 2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Замын-Үүд сумын Засаг дарга 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Замын-Үүд сумын Засаг дарга 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудын хүрээний байгууллагад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн санал дүгнэлтийг нэгтгэн үзүүлэв.

### Санал дүгнэлтийн хэлбэр (Тоогоор)

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлтийн хэлбэр (Тоогоор)				Дүн
		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан	
<b>1</b>	ТШЗ	8	3	0	0	11
<b>2</b>	<b>ТБӨААН</b>					
	Дүн	8	3	0	0	11

### **3 Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Замын-Үүд сумын Засаг дарга нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1.1 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл**

Хөрөнгө оруулалтаар хийгдсэн ТАХ-нд гүйцэтгэлээр 1154.1 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Эдгээрээс хугацаандаа гүйцэтгээгүй, гэрээ сунгасан 72.2 сая төгрөгийн төсөвтэй 2 ТАХ -нд 70.9 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон байна. Энэхүү 2 ажлын гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний 5.3-т "Захиалагч нь гүйцэтгэсэн ажлыг актаар хүлээн авснаас хойш ажлын 10 хоногийн дотор төлбөрийг шилжүүлнэ" гэж заасан байна.

Энэ нь үнэн зөв байх, тохиолдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний 5.3-т "Захиалагч нь гүйцэтгэсэн ажлыг актаар хүлээн авснаас хойш ажлын 10 хоногийн дотор төлбөрийг шилжүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**3.1.2. Эрсдэл:** Гэрээний үүргийн биелэлт хангагдахгүй, улмаар ажлаа дутуу гүйцэтгэвэл олгосон санхүүжилтийн мөнгийг буцаан авахад хүндрэл үүсэх

**3.1.3. Өгсөн зөвлөмж:** Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний заалтуудыг мөрдөж, хяналт тавьж ажиллах

#### **3.2.1. Балансын данстай холбоотой асуудал**

Сум хөгжүүлэх сангаас зээл авсан иргэдийн зээлийн авлага, хүү, алдангийг үнэн зөв тооцож, тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Сум хөгжүүлэх сангийн бүртгэл дэх авлагын эхний үлдэгдлээр нийт 128 зээлдэгчээс 970.2 сая төгрөгийн авлагатай бөгөөд үүнээс 12 зээлдэгчдэд хасах тэмдэгтэй 1.4 сая төгрөг байна.

Энэ нь оршин байх, үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 "Үнэн зөв байх" гэсэн НББ-ийн зарчмыг тус тус зөрчсөн байна.

**3.2.2. Эрсдэл:** Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

**3.2.3. Өгсөн зөвлөмж:** Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн авлага, зээлийн хүү, алдангийг үнэн зөв тооцож тайлагнах.

**3.3.1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл**

Сумын төсвийн нийт орлогыг 6,218.0 сая төгрөгөөр төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 6,187.1 сая төгрөг орж 30.9 сая төгрөгөөр төлөвлөгөө тасарсан байна. Орлогын нэр төрлөөр авч үзвэл орлогын албан татвар 263.6 сая төгрөг, өмчийн албан татвар 0.1 сая төгрөгөөр давж биелсэн ба бусад татвар 232.7 сая төгрөгөөр, татварын бус орлого 61.9 сая төгрөгөөр тасарсан байна. Мөн аймагт төвлөрүүлэх орлогыг 28.9 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь хэмжилт, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 41.2.1 -д "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" тус тус зөрчсөн байна.

**3.3.2. Эрсдэл:** Төсвийн төлөвлөлт, хэрэгжилт бодитой бус байх,

**3.3.3.Өгсөн зөвлөмж:** Орлогын төсвийг үндэслэлтэй боловсруулж, орон нутгийн төсөвт оруулах орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллах,

**3.4.1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл**

Сумын төсвийн хөрөнгө оруулалтаар анх 12 ТАХ-нд 327.5 сая төгрөг баталсан ба 2018 оны 12 сард тодотгол хийж нийт 51 ТАХ-нд 1165.8 сая төгрөгийн төсөв баталсан байна. Орон нутгийн төсвийн төсөл боловсруулахдаа Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан аргачлалыг баримтлаагүй байна. Хөрөнгийн зардлыг нэр төрлөөр ангилж үзэхэд орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой 295.0 сая төгрөгийн зардал байгаа бөгөөд бусад 864.2 сая төгрөгийн зардал нь хамаарахгүй зардал байна.

Энэ нь үнэн зөв байх, тохиолдсон байх, иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан Орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлал /Хөрөнгийн зардал тооцох/-ыг тус тус зөрчсөн байна.

**3.4.2. Эрсдэл:** Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

**3.5.3. Өгсөн зөвлөмж:** Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлалыг мөрдөж ажиллах

**3.5.1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл**

